



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ХААЛГА ОНГОРХОЙ ҮЕД ХӨРШИЙН ХУВИАР ГЭРТ НЬ ОРСОН ҮЙЛДЛИЙГ ХУУЛЬ БУСААР НЭВТЭРСЭН ГЭЖ ҮЗЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2026/ХШТ/07

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 01 дугаар сарын 07-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь 2025 оны 06-р сарын 22-ны өдөр хохирогч О-ийн хүн байнга амьдрах зориулалттай нийтийн байранд хууль бусаар нэвтрэн орж, түүний эзэмшлийн “Айфоне-11 промакс” загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүх:** Шүүгдэгчийг хулгайлах гэмт хэргийг хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтрэч үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсгийн 2.1 дэх² заалтад зааснаар 2 жил хорих ял оногдуулж шийдвэрлэжээ.
- 2. Давж заалдах шатны шүүх:** Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
- 3. Шүүгдэгчийн өмгөөлөгчөөс хяналтын журмаар гаргасан гомдолд:** “...Анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь шалгаагүй, нотолбол зохих нөхцөл байдлуудыг бүрэн гүйцэд нотлоогүй атлаа хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн хэмээн дүгнэсэн байна. Шүүхээс шүүгдэгчийг гэм буруутай эсэхийг тогтоохын тулд зөвхөн объектив үйл баримт хангалтгүй бөгөөд гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэрийг зөв тогтоон

¹Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3814?daterange=2026/01/01%20-%202026/03/09%20&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хууль (2015)-ийн 17.1 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.



- тодорхойлох шаардлагатайгаас гадна эргэлзээ үүсвэл гэм буруугүйд тооцох зарчмын дагуу тухайн этгээдэд ашигтайгаар шийдвэрлэх нь хууль дээдлэх, шударга ёсны зарчимд тус тус нийцнэ. Иймд анхан болон давж заалдах шатны шийдвэрийг хүчингүй болгож, миний үйлчлүүлэгчийг цагаатгаж өгнө үү...” гэжээ.
4. **Хяналтын шатны шүүхээс:** Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндсэн нөхцөлүүдийн нэг болох гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь гэмт үйлдлийн илрэн гарсан хэлбэр, арга, гэмт хэрэг үйлдсэн орон зай, цаг хугацаа, ашигласан зэвсэг хэрэгсэл зэргээс шууд хамаарч, үүгээрээ хэргийн зүйлчлэл, оногдуулах ялын төрөл, хэмжээнд нөлөөлдөг онцлогтой.(26).³
 5. Тухайлбал, гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн арга, орон зай, цаг хугацаа, нөхцөл байдал, ашигласан зэвсэг хэрэгсэл зэрэг нь тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоосон Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэг, заалтын диспозицэд заагдсан бол объектив талын заавал байх үндсэн шинжид хамаарч, үүнээс шалтгаалж хэргийн зүйлчлэл тодорхойлогдоно. (27).
 6. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад **бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг хүн байнга амьдрах орон байранд нэвтэрч үйлдсэнийг уг хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр тогтоосон бөгөөд тэрхүү нэвтрэлт нь хууль бус байснаар энэ гэмт хэргийн шинж бүрэн хангагддаг болно.** (28).
 7. Энэ хэрэгт хохирогчийн гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан үйл баримт тогтоогджээ. Тодруулбал, шүүгдэгч нь “Тухайн өдөр архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, үүрээр өөрийнхөө утсыг хайгаад олоогүй, утсаа хайж байгаад нийтийн байрны хажуугийн айлд ортол **хаалга нь онгорхой байхаар нь тэр чигтээ ороход** эзэд нь унтацгааж байсан, улмаар зурагтын шүүгээн дээр байсан гар утсыг аваад гарсан” талаар тодорхой мэдүүлсэн байна. Тус мэдүүлэг нь хохирогчийн “...тоотод байх нийтийн байрандаа нөхрийн хамт ирээд гадаа халуун болохоор нь **хаалгануудаа онгойлгоод унтсан...**” гэх мэдүүлгээр давхар нотлогдож, харилцан уялдаа бүхий байдлаар гэмт хэргийн үйл баримтыг нотолжээ. (30).
 8. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг, тухайн гэмт хэргийг үйлдсэн сэдэлт, санаа зорилгын хамт тогтоох ёстой бөгөөд **шүүгдэгч нь хохирогчийн гэрт нэгэнт нэвтэрсний дараа утас хулгайлах хүсэл зориг үүссэн** гэж дүгнэхээр байна. (34).
 9. **Гэрийн хаалга онгорхой байхад хөршийн хувиар орж байгаа үйлдлийг хууль бусаар нэвтэрсэн,** түүнчлэн гэрт орохоосоо өмнө тэрээр гэрт байгаа хүмүүс унтаж байгааг мэдсэн байх, мөн хохирогчийн гар утсыг хэн нэгэнд мэдэгдэлгүйгээр хулгайлах боломж байгааг гэрт нэвтрэхийн өмнө урьдаас мэдэж төлөвлөж үйлдсэн гэж дүгнэх, нөхцөл байдал тогтоогдоогүй болно....” гэжээ. (35).
 10. Дээрх байдлаас дүгнэж үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүх шүүгдэгчийн хохирогчийн гар утсыг хулгайлсан үйлдэл нь хэрэгт авагдсан нотлох баримт болох шүүгдэгч, гэрч, хохирогч нарын мэдүүлгээр хөдөлбөргүй

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн шийдвэрийн цогцолборын дугаар болно.



тогтоогдож байхад түүний үйлдсэн гэмт хэргийг “**орон байранд нэвтэрч**” үйлдсэн гэж хүндрүүлэн зүйлчилж шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэжээ. (48)

11. Иймд “...шүүгдэгчийн үйлдэлд прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдсэнийг мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлэн өөрчилж, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлуудыг хэрэгсэхгүй болгохоор тогтов...” гэжээ.

---o0o---